

БАТЛАВ:  
СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА Н.ӨНХБОЛД

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ГЭР ХОРООЛЛЫН БҮСГИЙН АШИГЛАЛТЫН  
СУУРЬ СУДАЛГАА ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 06 дугаар сарын 11-ны өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

1.	Төсөл боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none"><li>- "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 3.6.10, 9.3.17 дахь заалт;</li><li>- МУ-ын "Газрын тухай хууль"-ийн 24 дэх зүйлийн 24.1 дахь заалт</li><li>- "Газар зохион байгуулалт хийх журам" Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06</li><li>- Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрын 6.1.4.1 дахь заалт;</li><li>- Сүхбаатар Дүүргийн Засаг Даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 6.1.3 дахь заалт;</li><li>- Сүхбаатар дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн Дүүргийн 2024 оны төсөв батлах тухай 11/67 дугаар тогтоолын 4.2 дахь заалт;</li></ul>
2.	Байршил, эдэлбэр газрын хэмжээ	Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрийн 12, 13, 14 дүгээр хороо
3.	Төсөл гүйцэтгэх хугацаа	Захиалагч гүйцэтгэгч талуудын байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
4.	Ажлын иж бүрдэл	<ul style="list-style-type: none"><li>- 12, 13, 14 дүгээр хорооны газар нутгийн хэмжээнд RTK дрон ашиглаж агаарын зураглал хийх /Ortho, Dem, нарийвчлал <math>\pm 10</math> см хэвтээ, <math>\pm 10</math> см босоо/</li><li>- 12, 13, 14 дүгээр хорооны хорооны газар ашиглалтын суурь судалгаа хийх</li><li>- 12, 13, 14 дүгээр хорооны газар ашиглалтын одоогийн байдалд дүн шинжилгээ хийх;</li><li>- 12, 13, 14 дүгээр хорооны газар ашиглалтыг зураглах</li><li>- 12, 13, 14 дүгээр хорооны газар ашиглалтын ирээдүйн өөрчлөлтийн шинжилгээ хийх</li><li>- 12, 13, 14 дүгээр хорооны газар ашиглалтын зөрчлийн төрлийг тодорхойлж зураглах</li><li>- 12, 13, 14 дүгээр хорооны газар ашиглалтыг сайжруулах, зөрчлийг арилгах талгаар зөвлөмж боловсруулах</li></ul>

5.	Гүйцэтгэх ажил	<ul style="list-style-type: none"> <li>- 12,13, 14 дүгээр хорооны газар нутгийн хэмжээнд дрон технологи ашиглаж газар ашиглалтын зураглах хийх</li> <li>- 12, 13, 14 дүгээр хорооны газар нутгийн хэмжээнд ГЗБ-ын хээрийн судалгааг гүйцэтгэх</li> <li>- 12, 13,14 дүгээр хорооны газар ашиглалтын зөрчлийг тодорхойлж, зураглах</li> </ul>
6.	Төслийн захиалагч	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын Газар
7.	Төсөл боловсруулах байгууллага	<p>Барилга хот байгуулалтын яамнаас олгосон Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх хүрээнд дараах мэргэжлийн байгууллагын эрхтэй аж ахуй нэгж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Газар зохион байгуулалтын төлөвлөлт</li> <li>- Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа</li> <li>- Газрын нөхөн сэргээлт</li> </ul> <p>Аж ахуй нэгж нь дараах төслийн багийг бүрдүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Төслийн багийн ахлагч нь газар зохион байгуулалтын зөвлөх инженер эсхүл мэргэшсэн инженер зэрэгтэй үндсэн ажилтан байна.</li> <li>• Төслийн багийн гишүүд нь ажил гүйцэтгэх гэрээтэй газар зохион байгуулалтын зөвлөх инженер эсхүл мэргэшсэн инженер зэрэгтэй 4-с доошгүй инженерүүдээс бүрдэнэ.</li> <li>• Тусгай зөвшөөрөл бүхий байгууллага нь сүүлийн 2 жилд аймаг, сумын түвшний газар зохион байгуулалтын төлөвлөгөөний (бүрэн дуусган хүлээлгэн өгсөн) 3-оос доошгүй ижил ажлын туршлагатай байна.</li> </ul>
8.	Техникийн шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>- Гүйцэтгэж буй ажил нь Монгол Улсын хууль, эрх зүйн орчинд нийцсэн байх;</li> <li>- Мэдээллийн чанар, орон зайн мэдээллийн дэд бүтцийн өгөгдлийн стандарт шаардлагыг хангасан байх;</li> <li>- Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан байх</li> <li>- Гүйцэтгэгч нь энэхүү ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай өөрийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр бүрэн хангагдсан байх;</li> <li>- Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолоор батлагдсаны дагуу геодезийн байрлалын сүлжээг WGS-84 солбицол, өндрийн сүлжээг Балтийн тэнгисийн өндрийн тогтолцоонд байгуулж зураглалыг UTM тусгагт зохионо.</li> <li>- “Үндэсний стандарт шинээр батлах тухай” Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны А/36 дугаар тушаал</li> <li>- Газар ашиглалтын зургийг 1:1000, 1:2000, 1:5000 масштабын зургийн таних тэмдэг, атрибут мэдээллийн тоон өгөгдлийн стандарт</li> <li>- Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолын дагуу солбицол, өндрийн нэгдсэн тогтолцоонд гүйцэтгэнэ;</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>- MNS 3237:1989 Ерөнхий төлөвлөгөө. Зам тээврийн таних тэмдэг, дүрслэл;</li> <li>- MNS 5873:2008 Барилгын зураг. Ерөнхий төлөвлөгөөний ажлын зургийн таних тэмдэглэгээ;</li> <li>- Барилгын орчны тохижилтын ажлын норм ба дүрэм /БНБД 3.01-06-90/;</li> <li>- Газар зүйн мэдээллийн системийн ArcGIS программ хангамжийг ашиглан тоон зургийг боловсруулах;</li> <li>- ГХГЗЗГ (хуучин нэрээр)-ын даргын 2016 оны А/206 дугаар тушаалаар батлагдсан "Улс, бүс, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний зургийн тоон мэдээлэл боловсруулах заавар"</li> <li>- ГХГЗЗГ (хуучин нэрээр)-ын даргын 2009 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/224 дугаар тушаалаар батлагдсан "Газрын нэгдмэл сангийн тоо бүртгэл хөтлөх журам"</li> <li>- ГХГЗЗГ (хуучин нэрээр)-ын даргын 2015 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/22 дугаар тушаалаар батлагдсан "Газар, байгалийн нөөц эдэлбэрийн зүй ёсны эрхийг бүртгэн баталгаажуулах түр заавар"</li> <li>- Тайлан, судалгаа, тоон зураг болон бусад холбогдох материалыг тоон хэлбэрээр ГЗБГЗЗГ (хуучин нэрээр)-ын даргын 2020 оны А/40 дугаар тушаалаар батлагдсан</li> </ul>
9.	Хүлээлгэн өгөх материал	<ul style="list-style-type: none"> <li>- Ажлын тайлан 2 хувь;</li> <li>- Боловсруулсан нэгж талбарын сүлжээний зураг хэвлэмэл 2 хувь;</li> <li>- Тайланд дагалдах журамд заасан бусад баримт бичиг 2 хувь;</li> <li>- Тоон мэдээлэл /DVD/;</li> </ul>
10.	Төрийн нууцыг хадгалах, хамгаалах	Гүйцэтгэгч нь Монгол Улсын Төрийн болон албаны нууцын тухай хууль, "Төрийн болон албаны нууцыг хамгаалах тухай журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, ажлын даалгаварт заагдсан ажлыг ажлын даалгавар, гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу хүлээлгэн өгнө.
11.	Даалгаварт тусгагдаагүй ажил	Даалгаварт тусгагдаагүй ажлыг нэмэлт нөхцөлөөр гүйцэтгэж болох ба үүнийг гэрээний тусгай нөхцөлөөр тодорхойлно.

БОЛОВСРУУЛСАН:

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН ДАРГА

М.БЯМБАСҮРЭН/

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ИНДЕКС, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖЛЫН ГАЗРЫН АСУУДАЛ  
ТЕХНИКИЙН БАРИМТ БИЧИГ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.БАТ-ЭРДЭНЭ/